



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/137

Биндэр сум

**Шуурхай арга хэмжээ
авч ажиллах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1 дэх заалт, 5.5.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зэрлэг ан амьтны нөлөөллөөс хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, иргэд, хуулийн этгээдэд хохирол учруулахаас сэрэмжлэх, ховор, нэн ховор амьтдыг эрсдэлээс хамгаалах ажлыг шаардлагатай тохиолдолд шуурхай зохион байгуулах багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Отгонбаяр

Засаг даргын орлогч

Гишүүд:

Н.Болормаа

Баян-Өндөр багийн Засаг дарга

Э.Мөнгөншагай

Мандалхаан багийн Засаг дарга

Ж.Ганзоригт

Баянгол багийн Засаг дарга

Х.Амарзаяа

Дэлгэрхаан багийн Засаг дарга

Б.Тунгалаг

Онон багийн Засаг дарга

Х.Гэлэгжамц

Мал эмнэлгийн тасгийн дарга

Ч.Оюунбат

Байгаль хамгаалагч

Н.Болор-Эрдэнэ

Байгаль хамгаалагч

Т.Нарангарав

Байгаль хамгаалагч

М.Чимэг-Очир

Хэсгийн төлөөлөгч, ахмад

Т.Батбаяр

Засаг даргын Тамгын газрын жолооч

Л.Амгалан

Ачин иргэн

2.Шуурхай багийн ажлын зардлыг гүйцэтгэлээр тооцож Засаг даргын Нөөц сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Г.Амгаланцэцэг)-д зөвшөөрсүгэй.

3.Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг шуурхай зохион байгуулж, байнгын бэлэн байдлыг хангаж, хэрэгжилтийг тухай бүр тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (М.Отгонбаяр)-д даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн А/104 захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН

